



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийг 2019 онд арчлан тордох, мод, сөөг, зүлгийг шинээр болон нөхөн тарих ажлыг гүйцэтгэсэн цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллагуудын ажлыг үнэлэн санал дүгнэлт гаргах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Цэцэрлэгжүүлэлтийн мэргэжлийн байгууллагуудын ажлыг дүгнэсэн үнэлгээ, дүгнэлтийг Хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /М.Гансэлэм/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА *M. Gantselam* Т.ГАНСЭЛЭМ



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2020 оны *Дунд* сарын *13* өдрийн  
*М* тушаалын хавсралт.



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	М.Гансэлэм	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Д.Сүхбат	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн Ногоон, байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Нааяа	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн Ногоон байгууламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Лувсанчимэд	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Л.Баатарцогт	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн Ногоон байгууламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн